

L376

Ногоон Цэндийн Атарсаа, Гэлэнхүү нар

Он сар өдөр, төрсөн газар	Төв аймгийн Өндөрширээт сум
Үндсэн сүм хийд	Туулын хүрээ (Гүнгийн хүрээ)
Б.Ринченгийн сүм, хийдийн нэр	Туулын хүрээ /Навааннэрэн гүнгийн хүрээ/
Ярилцлаганд дурдагдсан бусад сүм хийдүүд	Гандантэгчинлэн

**- Хийд анх байгуулагдсан түүхийн тухай?**

Хийд анх дан жижиг сүм байхад, засаг ноён Навааны нэрээр Наваан Хүрээ гэж нэрлэдэг байжээ. Харин дараа нь тус хийдийг тухайн газрын нэрээр Туулын Хүрээ гэж нэрлэх болжээ.

**А.Шаарий:** Туул Гүнгийн Хүрээ нь Монголын хамгийн том, нэртэй хоёр хүрээ болох Эрдэнэ Зуу, Их Хүрээний хийдтэй адил цар хүрээтэй Гэлүгва (Шарын шашны) хийд байжээ.

**- Хэдэн ламтай байсан бэ?**

Хийдийг устгах үед, тус хийд нь нэг хавтгай дөрвөлжин га талбайтай байсан бөгөөд лам нарын гэр сууц бүхий байжээ. Тус хийд (одоогийн Лүн сумын нутаг дэвсгэр дэх) эргэн тойрны 30-40 км нутаг дэвсгэрээс ирж шавилсан 1000 гаруй ламтай байв.

**- Та мөн хүрээнд шавилан сууж байв уу?**

**Гэлэнхүү:** Би шавилдаг дацангийнхаа ойр гэрт ах нарынхаа хамт амьдардаг лам байлаа. Ер нь ихэнх лам шавь нар гэр бүлтэйгээ эсвэл лам багштайгаа гэрт амьдардаг байсан.

**- Хүрээнд суудаг айл өрх хэр олон байв?**

Хийдийн эргэн тойронд дөрвөн суманд хуваагдсан 150 орчим өрх (өнөөгийн ...дүгээр “баг” гэх газар) байсан бөгөөд хийдэд таван хошуу малаасаа (морь, үхэр, сарлаг, хонь, ямаа) “өргөж”, хийдийн хөрөнгө, санг ихээхэн нэмэгдүүлж байв.

**- Бөө байсан уу?**

**Гэлэнхүү:** Энэ нутагт бөө байгаагүй.

**- Хүрээ хэдэн дуган, дацантай байв?**

Тус хүрээ хийд нь хашаа, хайсгүй байсан ба Цогчин хэмээх их том гол сүм, болон Мамба; Дуйнхорын, Сахиусны, Чойрын (Гүн ухаан); ба Төвд хэв маягаар баригдсан Жүд тарнийн сургууль хэмээх таван дацантай байжээ.

**- Модон барилга байсан уу, эсвэл тоосгон?**

Бүх дуган, дацан нь Улаанбаатар хотын Гандантэгчинлин дэх зарим сүм дугантай ижил хийцтэй буюу алтан эсвэл алтадмал зэс асар дээвэртэй дөрвөлжин хэлбэртэй модон барилгууд байв.

**- Суварга байсан уу?**

Хийдийн гол үүд нь уламжлалын дагуу өмнө зүгрүү хандсан ба хийдийн ар хэсэгт болон сүмүүдийн хооронд 8 орчим суварга байсан. Тус хийдэд хийдийн том сүргийг хариуцдаг олон Жас байв. Жас

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

нь хийдийн хөрөнгө бөгөөд ихэвчлэн цөөн тооны лам сүм хийдийн сүргийг хариуцдаг буюу хийдийн эд хөрөнгийг хадгалдаг жижиг барилгаас бүрддэг байв.

### **- Хятад худалдаачид байсан уу?**

Хийдийн ойр орчмоор хятад худалдаачид дайран өнгөрдөг байсан ч суурьшиж байгаагүй. Тэд ноос, эсгий зэрэг амьтны гаралтай бүтээгдэхүүн авах, оронд нь хоол хүнс, даавуу (ялангуяа торго) арилжихаар Бээжингээс ирдэг байжээ.

### **- Ямар хурал хурдаг байв?**

Мамба хурал, Дүйнхор хурал, Сахиусны хурал, Чойрын хурал, Жүдийн хурал гэсэн таван дацангийн онцлогт тохирсон том уншлага, хурлын зан үйл /ёслолуудтай байсан. Хурал номын үеэр шашин номын судар бүтээлийг уншиж хурдаг байв. Цагаан сарын дараа уншдаг 14 хоногийн Ерөөлтэй дүйцэхүйц том хурлууд ч хурдаг, мөн өнөөгийн шашны зан үйлтэй ижил төстэй бусад зан үйлүүд ч байжээ. Туул Гүнгийн Хүрээ, Гандантэгчинлин хоёр харилцаатай байсан байх магадлалтай.

### **- Хамба лам нь хэн гэж хүн байв?**

**Гэлэнхүү:** Туул Гүнгийн Хүрээний их том ламыг Минжир Аграмба гэдэг байсан.

### **- Хийд хэдэн онд хаагдсан бэ?**

Хувьсгалчид 1938 онд уг хийдийг сүйтгэж, лам нарыг баривчлан, Лүн тосгонд шилжүүлсний заримыг тэнд хороосон байна. Хийдийг устгасны дараа туурийн үлдэгдэл, барилга байгууламжийн материалын заримыг Бор-Өндөр рүү зөөж сургууль, цэцэрлэг барихад ашигласан бол заримыг нь Улаанбаатарт аваачиж нисэх онгоцны буудлын барилгад ашигласан. Тухайн үеийн хамба лам нь хийдээс зарим чухал Бурхны шашны шүтээн урлал, ном судраас авч үлдсэн.

### **- Та хийдийг хаагдтал шавилж байсан уу?**

**Гэлэнхүү:** Хийд сүйтгэгдэх үеэр өөрийн төрсөн нутаг Баяртцахирт амьдарч байсан, чухал ном судрыг хийдээс авч явсныг бол мэдэж байна. Тухайн үед хэлмэгдүүлэлт их ширүүн байсан тул бага балчир байсан тэрбээр юу болсныг сайн мэдэхгүй, хавь ойрын хүмүүс нь энэ талаар бараг ярьдаггүй байсан.

### **- Хүмүүс юу болсон талаар ярьвал баривчлагдана гэж айж байсан болов уу?**

Магадгүй.

Ярилцсан: М.Жужа, Т.Кристина, 2004